

## МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН БАЯЛГИЙГ АШИГЛАХ ЯВЦАД ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

М.Бүрэнжаргал\*

### Товч агуулга:

Энэ зууны эхэн үеэс олон улсын зах зээл дээрх байгалийн баялгийн бүтээгдэхүүний үнэ ханш ихээр өсөхийг дагалдан уул уурхайн баялгийг голлон ашиглах болсонтой уялдан Монгол Улсын эдийн засгийн өсөлт хурдацтай нэмэгдэж хөгжлийн тааламжтай байдалд оржээ. Гэвч Монголын улс төр, эдийн засаг, газар зүйн өвөрмөц онцлогоос болж уул уурхайн баялгийг ашиглах явцад зарим ашиггүй байдал тулгамдаж байгаа ба тус өгүүлэлд эдгээр асуудалд ажиглалт хийсэн болно.

**Түлхүүр үгс:** Монгол улс, уул уурхайн баялгийн ашиглалт, тулгамдсан асуудал

### Нэг. Монгол Улсын уул уурхайн баялаг болон холбогдох хууль дүрмийн тухай

**2**009 оны холбогдох тоо баримтыг үндэслэвэл Монгол улсад уул уурхайн баялаг нь 80-аас дээш төрөл байдаг бөгөөд барагцаалбал 1200 орчим уурхай, үйлдвэр байна.

1. Нүүрс бол Монголын хамгийн арвин баялаг нөөцтэй байгалийн баялаг юм. Одоогоор 250-аад нүүрсний орд газар байгаа бөгөөд нүүрсний нөөцийн хэмжээ нийтдээ 120 тэрбум тонн ба эдгээр нөөц нь олон газарт тархан байрлажээ. Үүнээс Монголын зүүн бүс нутгийн нүүрсний чанар нь сайн, нөөц ихтэй байдаг. Таван толгойн нүүрсний уурхай бол дэлхий дээрх хамгийн их нөөцтэй нүүрсний уурхай бөгөөд нүүрсний нөөцийн талбайн хэмжээ нь 400 км<sup>2</sup>, нүүрсний давхаргын зузаан нь 190 м. Тус уурхайн нүүрс нь коксжих чанар маш өндөр байдаг дэлхий дээрх хамгийн ховор төрлийн нүүрс юм.

\*М.Бүрэнжаргал – Өвөр Монголын их сургуулийн монгол судлалын сургуулийн багш, доктор (Ph.D)

2. Монгол улс нь зэсийн нөөц ихтэй бөгөөд одоогийн байдлаар хайж тогтоосон зэсийн нөөцийн хэмжээ 200.0 сая.тн, Ази тивдээ энэ нөөцөөрөө тэргүүн байрт ордог. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр нь зэс, молибдений хүдрийн олборлолт, баяжуулалтын Монголын хамгийн том үйлдвэр юм. Оюутолгой бол дэлхий дээрх томоохон зэс алтны уурхайн ордод орох ба зэсийн төмөрлөгийн хэмжээ нь бараг 26.3 сая тн. , алтны нөөц нь 10580.0 тн байна.

3. Мөн газрын тосны нөөц элбэг бөгөөд голдуу Монголын өмнөд ба зүүн бүсийн Дорнод, Дорноговь болон Төв аймгаар тархжээ. Монголд одоо 22 газрын тосны уурхай байх бөгөөд одоохондоо мэдэгдсэн нөөцийн хэмжээ нь барагцаалбал 6000.0-8000.0 сая баррель байна .<sup>1</sup>

4. Ховд аймагт байгаа Халзан бүрэгтэйн орд газар бол дэлхий дээрх газрын ховор элементийн хамгийн их нөөцтэй орд юм. 100 000 тн газрын ховор элемент болох иттрий болон 1000 мян.тн ховор элементийн ислийн нөөц хадгалагдаж буй. Эдгээрээс гадна их хэмжээний жонш, фосфорийн хүчлийн давс, молибден, вольфромийн нөөц бий.<sup>2</sup>

1997 онд Монгол Улсын Их Хурал ашигт малтмалын тухай хуулийг баталжээ. 2006 онд Монгол Улсын Их Хурал энэ ашигт малтмалын тухай хуулиа шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан ашигт малтмалын тухай хууль нь дараах хэдэн талын онцлогтой .

1. Монголын уул уурхайн ашигт малтмалыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, тархац ихтэй ашигт малтмал, энгийн тархацтай ашигт малтмал гэж 3 хуваасан нь Монголын төр засгаас байгалийн баялгаа эзэмших байдлаа чангатгасан хэрэг болсон.

2. Ашигт малтмалын лиценз олгох үйл ажиллагааг хууль дүрмийн дагуу ил тод нээлттэй болгосон.

3. Уул уурхайн хайгуул ба олборлолтын явцад лиценз эзэмшигчид монголын иргэдийг ажлын байраар хангах үүрэгтэй.

4. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчид уул уурхайн баялгийг ашиглахад адил тэгш эрхтэйгээр оролцоно.

5. Орон нутгийн засаг захиргаанаас байгаль орчин экологио хамгаалах шинэ шаардлагыг тогтоосон.

2008 оны олон улсын эдийн засгийн хямралаар Монголын экспортлох бүтээгдэхүүний эрэлт ба үнэ ханшийн хэмжээ ихээр буурсан байна. Шууд хөрөнгө оруулалт 1/3 хувиар буурч нийт экспорт 1/5 хувиар буурчээ. Улсын уул уурхайн баялгийн татварын орлого их хэмжээгээр буурсан байна.<sup>3</sup> Ийм нөхцөл байдал Монголын хууль тогтоогчид эдийн засгийн уналтаас гарахын тулд

гадаадын хөрөнгө оруулагчдыг татах хэрэгтэй болсныг мэдэж засгийн газраас хөрөнгө оруулагчдыг татах тогтоол журмуудыг тасралтгүй гаргаж байсан.

**Хоёр. Монгол улс ашигт малтмалаа ашиглаж буй төлөв байдал**

Уул уурхай, ашигт малтмалын үйлдвэрлэл Монгол улсын эдийн засгийн хөгжилд чухал байр суурьтай. Дэлхийн эдийн засгийн хөгжлийн цөм нь Ази руу шилжсэн тааламжтай нөхцөлд өнгөрөгч 10-аад жилд Монгол улсын байгалийн нөөц баялаг их хэмжээний гадаадын хөрөнгө оруулагчдыг татсан байна. Монголын хөрш орон Хятад болон Япон, Орос, Солонгос улсууд бол дэлхий дээр уул уурхайн баялгийн эрэлт ихтэй байдаг улс орнууд бөгөөд эдгээр улс нь дэлхий дээрх нэг жилд гаргаж байгаа нийт нүүрсний тэн хагас, газрын ховор элементийн 80 орчим хувийг авч ашигладаг байна. Монгол улс нь эдгээр 4-н улстай нөхөрсөг харилцаатай нь илүү давуу нөхцлийг бүрдүүлж байдаг.

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбар тэргүүлэх байр суурийг эзэлж байна. Тухайлбал, Монгол Улсын Уул уурхайн яамны эх сурвалжаас үзвэл, 2012 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүнийн 20 гаруй хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 74%, хөрөнгө оруулалтын 85%-ийг тус тус эзэлж, төсвийн орлогын 25 орчим хувь, түүнчлэн экспортын орлогын 90 орчим хувийг бүрдүүлж байна. Энэ салбарт нийт 400 орчим уурхайд 50 мянга гаруй хүн ажиллаж байна.<sup>4</sup> Монголын уул уурхайн үйлдвэрлэл 2009 онд ДНБ-ий 22.5%-ийг эзэлж хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлээс анх удаа даван гарч тэргүүлэгч үйлдвэрлэл болсон. Уул уурхайн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт ба олборлолтын өртгөөс авч үзвэл 2003 оноос хойш хурдацтай өсч 2012 оны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 3.9 тэрбум ам.долларт, олборлолтын өртөг нь 3.4 их наяд төгрөг хүрчээ.<sup>5</sup> 2011 онд Монголын нийт экспортын хэмжээ 4800 сая ам.доллар байж тэр дундаа 90 хувь нь эл төрлийн уул уурхайн бүтээгдхүүн буюу барагцаалбал 4300 сая ам.доллар байв.

**Гурав. Монголын уул уурхайн баялгийн ашиглалтын явцад тулгамдсан асуудлууд**

Монгол улсын уул уурхай ашигт малтмалын арвин их нөөцтэй байх давуу талтай бөгөөд түүнийгээ их хэмжээгээр ашиглах явдал нь дэлхийн олон орны анхаарлыг ихээхэн татахын зэрэгцээгээр өнөөгийн хөгжлийн явц дахь тулгамдсан дараах хэдэн асуудал нь хүмүүсийн ярилцах сэдэв болж байна.

**Нэгдүгээрт:** *Дэд бүтцийн бүтээн байгуулалт хоцронгуй*

*учраас олборлолтын өөрийн өртгийг нэмэгдуулжээ.*

Монголд улсын чанартай зам 11063 км бөгөөд түүнээс бетон болон засмал зам 11.9 хувь, хайрган зам 12.5 хувь, шороон зам 75.6 хувийг тус тус эзэлж байна.<sup>6</sup> Үүнээс гадна олонх замууд нь элэгдэж хуучирсан тул байгаль цаг уурын бэрхшээлтэй нөхцөлд төөрөх аюул нүүрлэдэг. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэсэн машин техникийн хурдыг хязгаарладаг бөгөөд том машины явахыг мөн хязгаарладаг учир зам тээврийн үр ашиг муу байдаг. Байгалийн гамшигт үзэгдлээс болон уул усыг тойрч гардаг шалтгааны улмаас 500 км замыг 5-6 өдөр явж туулдаг. Ийм дэд бүтцийн хөгжлийн хоцрогдмол байдал нь уул уурхай, ашигт малтмалын ашиглалтын бүтээмжид ихээхэн муугаар нөлөөлж байна.

**Хоёрдугаарт:** *Ус дутагдах шалтгаанаас болж уул уурхай, ашигт малтмалыг ашиглахад асуудал тулгардаг.*

Монголын тал нутгийн цаг агаарын эрс тэс уур амьсгалаас болж уул уурхай, ашигт малтмалын ашиглалт нь бэлчээрийг сүйтгэдэг. Хэрвээ экологийн хамгаалалтанд сайн анхаарахгүй бол усны дутагдалд маш ихээр орно. Монголын хойд хэсгийн цөөнх нутаг дэвсгэрийг эс тооцвол бусад нутаг нь элсэрхэг хуурай газар нутагт орно. Хуурай газрын цаг агаарын онцлогтой учир газар доорх усны нөөц бага. Монголын уул уурхай, ашигт малтмалын газрын доорх их хэмжээний нөөц нь усны дутагдлаас болж бүрэн ашиглахад төвөгтэй байхаар барахгүй бас байгалийн баялгийг ихээр сүйтгэх аюултай болж байна. Олонх уул уурхайн үйлдвэрийн газрууд нь бэлчээрийн усны нөөцийг булаалдах асуудал гардаг. Бэлчээр нутаг бол малчин хүний амь нас юм. Газар доорх усыг их хэмжээгээр уурхайд хэрэглэх нь газар доорх усны түвшныг доошлуулж, бэлчээрийн чанарыг эрс бууруулдаг. Иймээс газар зүйн байршлын хувьд Монголын өндөрлөгт уул уурхай, ашигт малтмалыг ихээр ашиглах нь үнэндээ зүйтэй эсэх тухай хүмүүс анхааралдаа авахгүй байхын аргагүй.

**Гуравдугаарт:** *Ашигт малтмалын лицензийн эрхийг авсан бизнесменүүдэд хөрөнгө оруулагчдын итгэх итгэлцэл муу байгаа нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах идэвхийг бууруулжээ.*

Монголын ашигт малтмалын лиценз нь хувь хүний гарт их хэмжээгээр орсон байна. Энэ нь хөрөнгө оруулагчаа төвлөрүүлж ажиллахад ашиггүй болгожээ. Олонх уул уурхайн хайгуулын шинжилгээний материал нь бүүр зөвлөлт оросын үеийн хуучирсан гүйцэд биш материалууд байдаг бөгөөд үүнээс болж уул уурхай ашигт малтмалыг ашиглахад нэн төвөгтэй болгож байдаг. Тэрчлэн

уул уурхайн олборлолтын эдийн засгийн үр ашигт ч муугаар нөлөөлдөг. Сүүлийн жилүүдэд гарч ирсэн монголын өөрөө хийсэн С болон D зэргийн хайгуулын судалгаа шинжилгээний материалууд нь ч найдваргүй байдаг. Эдгээр материалаар баримт болгож уул уурхайн баялгийг ашиглах нь хөрөнгө оруулагчдыг их хэмжээний эдийн засгийн хохиролд хүрэх эрсдлийг бий болгоно.

**Дөрөвдүгээрт:** *Хууль дүрэм ба төрийн бодлогын хувирамтгай байдал нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхолыг бууруулжээ.*

Зарим хятад судлаачдын үзэж байгаагаар Монгол улсын улс төрийн байдал нилээд тогтвортой хэдий ч ашигт малтмалын тухай хууль, тогтоол журмандаа тасралтгүй өөрчлөлт хийж хөрөнгө оруулагчдын шаардлагыг улам өндөр болгодог нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулдаг байна. Монголын холбогдох хуулийн заалтууд нь дотоодын компаниудийн талд хэт хэлбийж гадаад улсын хөрөнгө оруулагчдад хэт өндөр шаардлага тавьснаас хөрөнгө оруулагч улсуудын ашигт муугаар нөлөөлжээ. Уул уурхай, ашигт малтмалын хуулийн өөрчлөлт нь хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулагчдын бизнест хохирол авчирсан болохоор дараа дараагийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг улам бууруулж байна.

**Тавдугаарт:** *Их хэмжээгээр уул уурхай, ашигт малтмалыг ашиглахдаа Голланд өвчнөөс сэргийлэх нь зүйтэй.*

Голланд өвчин гэдэг бол жижиг дунд хөгжилтэй улс орны эдийн засгийн хөгжлийн явцад ямар нэгэн анхны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбар ихээр хөгжсөнөөс болж бусад салбарын хөгжил муудахыг хэлнэ. 20-р зууны 60-аад онд Голланд улс их хэмжээний газний нөөцийг олж илрүүлснээс Голландын засгийн газраас байгалийн хийн аж үйлдвэрийг ихээр хөгжүүлсэн байдаг. Гэвч хийн үйлдвэрлэлийн хөгжил нь Голландын бусад хүнд аж үйлдвэрийн салбарын хөгжилд ноцтой сөрөг нөлөө үзүүлжээ. 20-р зууны 70-аад он болоход Голландын мөнгөний ханш суларч, бүтээгдэхүүний экспорт буурч, ажилгүйдэл нэмэгдсэн бэрхшээлүүд тулгарчээ. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн явцад байгалийн баялгийн экспортод хэт түшиглэхдээ Голланд өвчинд нэрвэгдэхээс сэргийлэх хэрэгтэй. Учир нь Монгол улсын боловсруулах үйлдвэрийн хөгжил сул, хүний нөөц ба хөрөнгө мөнгө хүрэлцээ муутай байхаас гадна их хэмжээгээр уул уурхайн үйлдвэрийг хөгжүүлэх нь хүний нөөц болон хөрөнгө мөнгийг уул уурхайн аж үйлдвэрийн салбарт төвлөрүүлж, түүнчлэн бусад үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг боомилох болно.

## ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

<sup>1</sup> Сю Хайцин/许海清/: “Хятад Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны шинжлэл” / “基于利益共享的中蒙经贸合作关系研究” (J), “Зүүн хойд Азийн ярилцлагын индэр” / 《东北亚论坛》, 2011 оны 5-р.

<sup>2</sup> Ван Хайхуа/王海华: “Монгол улсын уул уурхайн аж үйлдвэрийн төлөв байдал болон чиг хандлага” / “蒙古国矿业现状与展望” (J), “Уул уурхайн мэдээ” / 《国土资源情报》, 2012 оны 5-р.

<sup>3</sup> Мөн тэнд

<sup>4</sup> Д.Ганхуяг: 400 орчим уурхайд 50 гаруй мянган хүн ажиллаж байна. <http://economics.gogo.mn/news>

<sup>5</sup><http://www.mram.gov.mn/images/stories/mram/MRAM%202013-1sar%20tailan.pdf>

<sup>6</sup> Ли Цинюй, Лей Ян/李靖宇、雷杨/: “Монголын уул уурхайн баялгийн тархалт болоод Хятад Монгол хоёр улсын хамтын ажиллагаа” / “蒙古国矿产资源分布与中蒙两国合作开发前景论证” (J), “Дэлхийн газар зүй шинжлэл” / 《世界地理研究》, 2010 оны 1-р.